



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/264

Арвайхээр сум

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг
үнэлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4.2, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, 52 дугаар зүйлийн 52.3, Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 1.2.1, Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 217 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, ажлын үр дүнгийн үнэлгээг хавсралтаар баталсугай.

2. Үр дүнгийн урамшууллыг дээд байгууллагын урамшуулалтай давхардуулахгүйгээр “А буюу Маш сайн”, “В буюу Сайн” үнэлэгдсэн байгууллагын дарга нарт үндсэн цалингийн 80 хувьтай тэнцэх мөнгөн урамшуулал тооцож олгохыг байгууллагын нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0914

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны ... дугаар
сарын ... ны өдрийн ... дугаар
захирамжийн хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ
АГЕНТЛАГУУДЫН 2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Д/д	Байгууллагын нэр	Төсвийн шууд захирагчийн нэр	Үнэлгээ
1.	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	Г.Баясгалан	"А буюу Маш сайн" 90,8%
2.	Биеийн тамир, спортын газар	Ө.Жамдүдсансүм	"А буюу Маш сайн" 99,3%
3.	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	Н.Цэвээндулам (түр орлон гүйцэтгэгч)	"В буюу Сайн" 81,2%
4.	Онцгой байдлын газар	Д.Одонбаяр	"А буюу Маш сайн" 94,2%
5.	Орон нутгийн өмчийн газар	З.Балданням (түр орлон гүйцэтгэгч)	"В буюу Сайн" 87,8%
6.	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	Н.Лхамдолгор (түр орлон гүйцэтгэгч)	"В буюу Сайн" 83,4%
7.	Стандарт, хэмжил зүйн хэлтэс	Г.Дэлгэрмандах	"А буюу Маш сайн" 98,9%
8.	Соёл, урлагийн газар	Д.Өсөх-Эрдэнэ	"В буюу Сайн" 86,4%
9.	Татварын хэлтэс	Н.Эрдэнэсүвд	"А буюу Маш сайн" 94,4%
10.	Улсын бүртгэлийн хэлтэс	Б.Цэдмаа	"А буюу Маш сайн" 97,2%
11.	Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	Ч.Чанцалдиймаа	"А буюу Маш сайн" 90,1%
12.	Хүнс, хөдөө аж ахуйн газар	С.Цэдэнбалжир	"А буюу Маш сайн" 91,0%
13.	Цагдаагийн газар	Г.Чимэддагва	"В буюу Сайн" 86,6%
14.	Эрүүл мэндийн газар	Д.Шивааннүрдэв	"А буюу Маш сайн" 90,2%
15.	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс	А.Эрдэнэтунгалаг	"А буюу Маш сайн" 97,2%